



АЛТАН ГАДАС ОДОНТ “ХОРИНХОЁР ДУГААР БААЗ” ХК

2019 оны 04 сарын 01 өдөр

№ 06

Улаанбаатар хот

“22-р БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Хорин хоёрдугаар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Энх тайвны өргөн чөлөө өөрийн байранд болов.

Хуралд :

- Монгол секюритиес ҮЦК ХК 380940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т.Эрдэнэбаатар 89020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 18808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- З.Номундарь 1 399 412 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Чингис Хаан секюритиес ХХК 56 870 ширхэг хувьцааны саналаар /захирал/

1 945 050 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 73,3 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Хурлыг: Т.Зоригтбаатар удирдав.

Хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцуулав.

Хурлаар:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
3. Санхүүгийн тайланд хийсэн Аудитийн дүгнэлт.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
5. Төслийн санхүүжилтийн тухай
6. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг
8-р хороо, “22-р Бааз” ХК-ийн байр
Утас: 976-70100708
Факс: 976-70100708

7. Бусад

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга З.Оюунбилэг ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 73,3 % байгаа тул Монгол улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 13 цаг 05 минутанд эхлэв.

Хурлын дарга Т.Зоригтбаатар : Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, ТУЗ-ийн дүгнэлтүүдийг уншиж танилцуулав. Мөн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрүүдийг танилцуулав.

Компанийн хашаанд баригдах үйлдвэрлэл үйлчилгээ, орон сууцны барилгыг эхлэх тухай, мөн санхүүжилтийн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлуудыг танилцуулж санал авах нь зүйтэй гэж үзсэн учираас төслийн санхүүжилтын талаар танилцуулав.

Ингээд санал асуулт эхлэв.

З.Номундарь: Өөрсдөө төслөө санхүүжүүлэх боломжгүй учраас хөрөнгө оруулагч нарт хандаж санхүүжилтээ шийдэхгүй бол болохгүй байна. Иймд хөрөнгө оруулагч нарт төслөө танилцуулж санхүүжилтийг шийдэх хэд хэдэн хувилбараар тохирох хэрэгтэй байна. Тиймээс Санхүүжилт олж, гэрээ хийх эрхийг ТУЗ-д өгөх дээр тохиролцох хэрэгтэй байна.

Үүнд хувьцаа эзэмшигч та бүхний санал хүсэлт хэрэгтэй байна. Ингээд та бүхэн энэ асуудалд ач холбогдол өгч санал хүсэлтээ хуваалцана уу?

Л.Гүндэгмаа: Энэ асуудлыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа, олон жил яригдсаар өдий хүрлээ. Барилгын салбарын үйл ажиллагаа харьцангуй сэргэж байгаа, хямд өртөгтэй стандартаар чанартай барилга барих нь зөв. Тиймээс ер нь хурдан энэ асуудлаа шийдэж барилга байгууламжаа эхэлсэн нь дээр.

Т.Эрдэнэбаатар: Зөвөө, одоо энэ төслөө хурдан эхлүүлэх хэрэгтэй. Ямар арга зам байна, түүгээр нь шийдээд барилга байгууламжаа эхлэх хэрэгтэй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжинэ байх гэж бодож байна. Удирдлагын түвшинд шийдээд эхлүүлэх нь зүйтэй.

Л.Гүндэгмаа: Ялангуяа үйлдвэрлэл үйлчилгээний барилгаа эхлээд барьчих хэрэгтэй. Мөн сургууль цэцэрлэгээ барьчихвал орон сууц зайлшгүй борлогдоно. Дэмжиж байна.

ХУРЛЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Т.ЗОРИГТБААТАР
Ш.НАРАНХҮҮ